

«МОНГОЛЫН НУУЦ  
ТОВЧОО»-НЫ 750 ЖИЛД

НУУЦ ТОВЧООНЫ ЭХ  
ЗОХИОЛЫН ТУХАЙ

Ч. Далай

Барагцаалбал гурван түмэн үсгээр илэрхийлэгдэж алтан ургийн нууц цэдэгээр гол агуулгаа хийсэн магад ч үгүй «алтан товичиян» буюу «алтан дэвтэр» нэртэйгээр анх бичсэн «нууц товчоог» эх монгол хэлээр бичсэн болохыг хэнбугай ч маргашгүй билээ. Алтан урагийнхны дотроос Өгөдэй хааны итгэлийг ихэд хүлээсэн нэгэн гарамгай бичгийн хүн дэдлэн уг зохиолыг 1240 онд хааны ордонд эмхэтгэн бичиж дууссан байдаг. Харамсалтай нь тэрхүү анхны худам монголоор бичсэн эх эдүгээ хүртэл олодохгүй байгаа бөгөөд бас ч гэж хойшид яг олодохгүй гэх газаргүй байж болох юм.

Өгөөдэй хааны өвөр дээр хуудас дэлгээтэй байсан тэр агуу зохиол бүтнээрээ эс боловч дутуу хагас эх болох зүйл олдож юу магад гэдэг бодол төрдөг. Ш. Озава<sup>1</sup>, И. Ренчин<sup>2</sup> нарын уйгагүй хөдөлмөрөөр сийрүүлэн бүтээсэн нууц товчооны худам монгол эхийг харахаар уг эх бараг тийм л байсан байх гэдэг бодол улам ч төрөх боллоо. Гэвч энэ нь олдсоосой гэсэн зөгнөл төдий л байх. Зарим зөгнөл бодит зүйл болдог ч ёс бий.

Наймдугаар зуунаас нааш монгол туургатны өвөг овгийн алтан хэлхээг хураангуйлан тэмдэглэсэн нууц товчооны эхийг бичиж эхэлсэн нь нэлээд дээр үеэс болой. Хамаг монгол улсын үед алтан ургийн гэрийн нууц түүхийн байдлаар ихээхэн боловсорсон нэгэн түүх хөтлөгдөж байжээ. Тэр түүхийг голдуу хадан гэрт нууцлан хадгалдаг байсан гэдэг. Тухайн үед монголчууд удам угсааныхаа түүхийг их ч эрхэмлэдэг, их ч нууцалдаг байжээ. XI-ХП зууны үед Манж угсааны Алтан улсын хаад нь монгол туургатан ялангуяа хамаг монгол улсын гол дайсан болж байв. Тэд монголчуудын нэгдэн нийлж улс байгуулахыг сөрөн зогсож байлаа. Тэр тусмаа монгол туургатны төв цогцос болсон хамаг монгол улсын хаадыг яс магнаасаа үзэн яддаг байжээ. Чухам ингэж Алтан улсын хаад юуны түрүүнд Хамаг монгол улсын хаадын угсааг таслах, эр зориг, эрдэм чадалтай хүмүүсийг цөөрүүлэн устгах, гэрийн түүхийг шатаах зэрэг ихээхэн хорлолтой ажил хийж байв. Ийм нөхцөлд хамаг монголын хаад алтан ургийнхнаар гол агуулгаа хийж гэрийн түүх байдлаар уламжлагдаж ирсэн эцэг өвгөдийнхээ удам түүхийг бичгээр тэмдэглүүлэхээсээ амаар цээжлүүлэх ажлыг илүү их чухалчилдаг байжээ. Ийм байдлаар эхэлсэн нууц товчоог маань 1240 онд эмхэтгэн бичиж дууссан байна. Нууц товчоог бичиж байхад удам угсаа, ураг дээдсийнхээ түүхийг олон үеэр цээжилсэн ухаантан хүмүүс олноор цуглаж, цээжилсэн зүйлээ хэлж бичүүлэх нь их байсан бизээ.

Нууц товчоо бол монгол туургатны 500 гаруй жилийн түүхийг багтаасан түүхийн хосгүй гайхамшигт зохиол бөгөөд бүхий л агуулгаараа монголын түүх юм. Монголын түүхийг маш бодит үнэнээр бичсэн байдаг. Монгол түмнийхээ эрт урьдын түүхийг судлан зохиоход түүхчдэд нууц товчоо гол сурвалж болдог юм. Иймээс монголын түүхчид нууц товчоогоо хүндэлдэг, хайрладаг, түүгээрээ бахархдаг. Өнөдөр та бид чухам ийм л агуу түүх бүтээгдсэн өлгий нутагт аж төрөн амьдарч байна. Тэрхүү агуу түүх бичиж төгссөний 750 жилийн ойг эх орондоо

тэмдэглэхэд сэтгэл хөдлөхгүй монголын иргэн нэгээхэн ч байхгүй нь мэдээж билээ.

1933 онд Бээжингийн төв номын сангийн байрны доторхи хааны ордны нэгэн байшин дотроос «Хуа-и и-юй» бичгийн 26 хуудас, нууц товчооны 41 хуудас олджээ.<sup>3</sup> Гэвч тэр нь анхны худам монголоор бичсэн эх биш, анхны хятадаар галиглан бичсэн эх бололтой юм. Ямар ч гэсэн Хятадын Мин улсын анхны Хаан Чжу Юанчжаний (1368— 1398) албат түшмэдийн гарт нууц товчооны худам монгол эхийн нэгэн хувилбар байсан нь тодорхой байдаг. Харин Тогоонтөмөр хаан 1368 онд Бээжингээс эх нутагтаа түрэгдэн гарч явахдаа зөвхөн өөрийн хаанчлалын үеийн «Үнэн түүх» (архив) -ийг амжин авч нууц товчоо зэрэг бусад хаадын архивыг авч чадаагүй бололтой юм. Гэвч энэ тухай гүйцэд нотолгоо хийгдээгүй байна. Мин улсын жанжин Сюй Да<sup>4</sup> Бээжинг эзлэхдээ юуны өмнө хааны ордны ном архивыг бүслэн эзэлсэн байдаг. Ингэж л нууц товчоо тэдний гарт орсон бололтой. Хархорум хотод монголын нууц товчооны анхны худам Монгол эх нууцлагдан хадгалагдсаар Мин улсын цэрэг хоёр удаа Хархорумыг довтолж эвдлэн шатаахад сүйдсэн байж болох талтай. Ялангуяа 1410 онд Хархорум хотод нэн их эд агуурс, ном судар шатсан тухай тэмдэглэл байдаг.<sup>5</sup>

Ер нь нууц товчооны анхны худам монгол эх алга болсон тухай олон янзын таавар байдаг. Аригбөх, Хубилайн дайнаар сүйдсэн, Аригбөх авч баруун хязгаар явсан, Хубилай авч Бээжин явсан, Өгөдэй хааны шарил дотор хийсэн, их бичгийн эрдэмтэн Тогтохын гарт байсан гэх мэт болно.

Нууц товчооны хятадаар галиглан бичсэн эхийг Мин улсын үед цоо шинээр боловсруулсан биш Юан гүрний Монгол хаадын ордонд нэгэнт хятадаар галиглан хажууд нь товч утгыг нь орчуулан хадаж эхэлсэн эхийг залган гүйцээсэн хэрэг болой. Энэ талаар БНХАУ-ын эрдэмтэн Ч. Хишигогтохтой<sup>6</sup> санаа нийлж байна.

Юан төрийн нууц товчин гэдэг нэр Хубилай хааны эцэс Өлзийт- Төмөр хааны эхээр бий болсон шиг байна. Одоо бидний гарын авлага болон судалж буй эх бол 600 гаруй жилийн гэртээ хятадын Мин улсын анхны хаан Чжу Юанчжаний зарлигаар худам монгол зохиолыг хятадаар галиглан буулгаж хажууд нь 560 гаруй дүрс үсгээр утгыг нь хадсан эх мөн. Өөрөөр хэлбэл хятадаар галигласан монгол эх юм. Хятадаар галигласан хоёр эх байх бөгөөд нэг нь 12 дэвтэр (бүлэг), нөгөө нь 15 дэвтэр болно. Энэ хоёр эхийн аль нь түрүүнд бэлтгэсэн талаар эрдэмтэд санал зөрөөтэй байдаг. Миний бодлоор бол 12 дэвтэр нь түрүүнд гарсан гэдэг санал нь илүү үнэмшилтэй магад байна. Ер нь 12 дэвтэр, 15 дэвтэр хоёр эх бол нууц товчооны 282 зүйлийг багтаасан, илүү дутуу зүйл нэмээгүй нэг л зохиол юм. Анхны хятадаар галигласан эх бараг бүрнээрээ шахам байхгүй болжээ.

Мин улсын Юн Лэ хаан «ар Юан» монгол улсыг олон удаа байлдан түйвээж монголын талаар нэлээд харгис түрэмгий бодлого явуулсан юм. Нэгэн зэрэг тэрээр монгол заншлыг бусад хятад хаадаас илүү мэддэг байжээ. Мин улсын нийслэлийг ч өөрийн гадаад бодлогод зохицуулан Наньжингаас Бээжинд шилжүүлэн авчирсан билээ. Тэр үед хааны архивыг нэгэн адил шилжүүлэн нүүлгэж Бээжинд хадгалахдаа нууц товчоог чухал номын байранд тавьжээ. Юн Лэ хаан өөрийнхөө сүр хүч, гавьяа зүтгэлийг өндөрт өргөн мандуулах зорилгоор хэдэн мянган боть төрийн их хөлгөн судрыг тавхан жилийн дотор эмхэтгэн зохиолгож «Юн Лэ-ийн их хуульт бичиг» хэмээн нэрлэжээ. Энэ хуульт бичгийн 5179—5193 хүртэлх 15 ботид Монголын нууц тов-

чоог 15 бүлэг хуваан нэг нэг дэвтэр болгон оруулжээ. Чухам ингэж 15 дэвтэр (бүлэг) нууц товчоо энэ үеэс бий болжээ. Харин анх эхлэн хятадаар галигласан эх бол 12 дэвтэр байсан гэдгийг дээр нэгэнт өгүүлсэн билээ.

Өнөөгийн бидний судлан баримталж буй эх бол дээрх хоёр төрлийн эхээс янз бүрээр хуулбарлан авсан эхүүд юм. 1562 онд Юн Лэгийн их хуульт бичгийг дахин сийрүүлэн хэвлэжээ. Тэр үед хятадаар галигласан монголын нууц товчоо бүрнээрээ байжээ. 1557 онд Мин улсын ордны дотор их гал гарснаас болж чухал ном архив хамгаалах, цэгцлэх, хуулбарлах ажил хийхэд нууц товчоо хамгаалалтад байсаар л байж. Магад ч үгүй хуулбарласан худам монгол эх ч хадгалагдаж байсан байж болох. Энэ талаар хойшид нарийвчлан судлаж шинэ шинэ мэдээ сэлт олдох байх гэж бодно.

Тогоонтөмөр хааны төрд алба хааж судар зохиох ажлаас эрс татгалзан оргон зугатааж эзгүй ууланд нуугдан 10 гаруй жил ном бясалгасан хятад түшмэл Сун Лян,<sup>7</sup> Ван Вэй<sup>8</sup> нар бол 1367 оноос Чжу Юанчжанд ихэд тоогдож 1368 оны эхээр хааны ордны түүх зохиох даамал түшмэл болцгоожээ. Тэднийг Юан төрийн түүхийг Наньжинд зохиож эхлэхэд хааны ордны номын сан хөмрөгт худам монголоор бичсэн ном их байснаас тэд зөвхөн нууц товчоог л хагас дутуу ашиглаж бусдыг үл тоомсорлов гэсэн мэдээ байдаг. Тэр ч байтугай «Татар бичигтэй цаасыг устгах» гэдэг урианы дор худам монгол бичгээр буюу дөрвөлжин монгол бичгээр бичсэн өдий төдий ном, судар, дурсгал, гэрийн түүх зарлиг, захидал зэргийг шатааж устгажээ. Энэ бол хятадын Мин улсын феодалын ноёрхогч ангиас монголчуудын соёлыг дайсагнан устгасан хамгийн их хилэнцэт ажил болсон юм. Тэр үед эцэг өвгөдийн маань ямар их түүх намтар байгаад яаж сүйдсэн бол гэж хэн бүхэнд бодогдох биз ээ.

1629 онд Юн Лэгийн их хуульт бичгийн ботиудыг сийрүүлэн сэргээх ажил хийсэн номын гарчигт 15 дэвтэр нууц товчоог дурьдаагүйгээс үзвэл дахин сийрүүлэлт хиймээргүй үсэг тодорхой байсан болов уу гэмээр. 12 дэвтэр монголын нууц товчоог 1748 онд Ван Гуантай<sup>9</sup> гэдэг хүн анхны эхээс нь хуулан авч «Юаний нууц товчооны товчлол» нэртэйгээр хоёр дэвтэр болгон хэвлэжээ. Алдаа мадагтай хуулсан боловч 12 дэвтэр нууц товчооны хятадаар галигласан анхны эхийг тэр хүн олж үзсэн байна. Магад ч үгүй энэ хүний үеэс нууц товчоо хувь хүний гарт орж эхэлсэн байж болох. Саяхан болтол нууц товчооны хятадаар галигласан анхны хоёр эхээс хуулбарласан 4 янзын эхийн аль нэгийг баримталж ирэв. Үүнд:

1. Гу Гуанчэ<sup>10</sup>-гийн хуулсан эх. Тэрээр 1770—1839 оны хооронд амьдрахдаа монголын түүх судлалд ялангуяа сурвалж бичгийг харьцуулан судлах ажилд зүтгэл гарган хэд хэдэн бүтээл туурвижээ. 1805 онд нууц товчооны 12 дэвтэрийг олж аваад 15 дэвтэр эхтэй харьцуулан тулгаж алдаа мадаг багатай 12 дэвтэр нууц товчоог бий болгожээ. Түүний бүтээсэн эхийг Шань Юй (1850-1899), Вэнь Тинши (1856—1904), Ли Вэньтянь (1834 — 1895) нар нэг нэгээсээ улируулан хуулж авчээ. Ийм байдлаар алдаа мадаг ихтэй олон эх бий болсон юм. Болж өгвөл Гу Гуанчэгийн эхийг л баримталбал сайнсан. Вэнь Тинши 1901 онд нууц товчооны нэгэн хуулбарыг Японд худалдсан байна. Тэр эхийг Накэ Мичиёо гэдэг эрдэмтэн орчуулан «Чингис хааны үнэн тэмдэглэл» нэртэйгээр 1907 онд Японд хэвлэжээ.

2. Е Дэхуй (1864—1927) бол Монголын түүх судлалд их хувь нэмэр оруулсан эрдэмтэн. Тэрээр Вэн Тиншигийн гэрт хадгалагдаж байсан 12 дэвтэр эхийг бас л бусад эхтэй тулган үг үсгийн алдааг залруулж «Юан төрийн нууц товчичян» гэдэг нэрээр 1908 онд хэв-

лүүлжээ. Энэ 12 дэвтэр нууц товчияныг Е Дэхуйн нууц товчоо гэж нэрлэдэг. Хятадын түүхчид энэ эхийг гол баримтлан судалгаа хийж иржээ. Е Дэхуйн нууц товчоог 1936 онд Шанхайд дахин хэвлэжээ.

3. Цянь Дасиний (1728— 1804) Юн Лэгийн их хуульт бичгээс хуулан авч «Юан төрийн нууц товчиян» гэдэг нэртэйгээр хэвлүүлсэн 15 дэвтэр эх байдаг. Цянь овогт 1772-1773 он хүртэл Бээжингийн судар зохиох төвийн хүрээлэнд ажиллаж хааны ордны доторхи архивыг үзэх эрх бүхий байсан учир Юн Лэгийн их хуульт бичиг дотроос анхны 15 дэвтэрийг олж үзээд хуулж авсан байж болох бүрэн үндэстэй. Гэхдээ яаж хуулснаа хэлээгүй байдаг.

Зарим эрдэмтэн Цянь овогт 15 дэвтэр нууц товчоогоо өөрөө хуулсан биш айлын гэрээс олсон байх гэж тааварладаг. Ямар ч гэсэн түүний хуулан эмхэтгэж хэвлүүлсэн 15 дэвтэр нууц товчоо нь дэлхийн эрдэмтэн мэргэдийн судалгаанд өргөн хэрэглэгдэж иржээ.

4. Чжан Му (1805-1849)-ийн 15 дэвтэр нууц товчоо гэж бий. Харьцангуй богино амьдралдаа ихийг бүтээж монголын нүүдлэлийн тэмдэглэл хэмээх алдарт зохиол бичсэн энэ бичгийн хүн 1841 онд Юн Лэгийн их хуульт бичгээс нууц товчоог хуулан авч Гу Гуанчэгийн 12 дэвтэр эхтэй тулгалт хийж «Юан төрийн нууц товчоог харьцуулсан нь» гэдэг зохиол хэвлүүлэв. Үүнийг Чжан Мугийн эх гэдэг. Б. Кафаров (1817-1878) -ын 1866 онд оросоор орчуулж Бээжинд хэвлүүлсэн «Чингис хааны тухай монголын эртний домог үг»<sup>11</sup> гэдэг нууц товчооны товчлол зохиол бол Чжан Мугийн 15 дэвтэрээс авсан гэдэг. Энэ нь үнэн байх бүрэн үндэстэй. Б. Кафаров 1872 онд Хан Тайхуагаас худалдан авсан эхээ тэр дор нь А. М. Позднеевээр дамжуулан Петербургт хүргүүлсэн байдаг. Зөвлөлт улс уг эхийг үргэлжлүүлэн нандигнан хадгалсаар 1933 онд гэрэл зургаар буулгаж Бээжингийн номын санд өгсөн бөгөөд мөн 1962 онд Москвад гэрэл зургаар хэвлэж судалгааны эргэлтэд оруулсан билээ.

Хятад дүрс үсгээр галиглан буулгасан монголын нууц товчооны ийм л 4 эх өнөө хүртэл үлдэж дотоод гадаадын эрдэмтдийн судалгааны гарын авлага болсоор иржээ. 1860 онд Англи, Францын цэрэг Бээжинг эзлэн түймэрдэн шатаах үед түүхийн дурсгал, ном судар их хэмжээгээр сүйджээ. 1890 онд өрнөдийн 8 улсын цэрэг Бээжинд довтлон орж бас ном судар, түүхийн дурсгалыг ихэд шатаажээ. Энэ үед л нууц товчооны хятадаар галиглан бичсэн анхны эх үгүй болсон бололтой гэж хятадын эрдэмтэд үздэг байна. Ямар ч гэсэн дээрх хоёр их сүйрлээс өмнө нууц товчоог хятадын эрдэмтэд хуулан авч хадгалсан байна. Ер нь монголын нууц товчоог өнөө үе хүртэл хадгалан үлдээхэд хятадын эрдэмтэн бичгийн хүмүүсийн гавьяаг үгүйсгэх аргагүй юм.

Одоо ч гэсэн БНХАУ-ын эрдэмтэд монголын нууц товчооны судлалд үнэт хувь нэмрээ оруулсаар байна. Тухайлбал эрдэмтэн Баяр<sup>12</sup>, Оюундалай<sup>13</sup>, Ардаажав<sup>14</sup>. Ринчин. Дугаржав<sup>15</sup>, Мансар<sup>16</sup>, Төмөрбагана,<sup>17</sup> Хишигтогтох нарын зэрэг эрдэмтдийн нэрийг дурьдаж болох юм.

Нууц товчоог бараг монгол туургатан өрх айл бүрийд хүргэсэн Ц. Дамдинсүрэнгийн нууц товчооны ач тус далай шиг их билээ. Гэвч жинхэнэ эрдэм шинжилгээний ажлыг хийхэд эрхбиш анхны галигласан эхийг баримтлах нь чухал юм.

Оюундалай, Элдэнтэй<sup>18</sup> нарын 1981 онд хэвлүүлсэн нууц товчооны хятадаар галигласан эх бол олон эхийг хооронд нь харьцуулан тулгаж алдаа мэдгийг засаж, бузгай сайн тайлбар хийсэн эх гэж үзэлтэй. Хойшдын судалгаанд энэ эхийг баримталбал илүү их боломжтой байж болох байна.

Монголын түүхийн үнэт сурвалж, Монгол туургатны гал голомтын буурал түүх болон үлдсэн Монголын нууц товчооны эх бичгийн талаар ухаантан мэргэдийн уран санд өөрийн ядуухан санаа оноог товчоор бичиж нэмэрлэхийг оролдсон нь энэ бүлгээ.

<sup>1</sup> Ш Озава, «Гэнчио хиши зэншеку» - («Монголын нууц товчооны бүрэн тайлбар»), 6 боть, Токио, 1983-1988 он Фукаан шёбо хэвлэлийн газар

<sup>2</sup> Их мянгадайн Ринчин «Монголын нууц товчичян», Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо, Хөх хот, 1987 он

<sup>3</sup> Юан гүрний үед монголын түүхийн судлалаар нэрд гарсан профессор Чэнь Юан өөрийн зохиол бүтээлдээ энэ тухай өгүүлсэн байдаг. «Чэнь Юан Сюэ-шу Лунь-вэнь Цзи»-гийн 2-р боть, 109-р тал

<sup>4</sup> Сюй Да бол Чжу Юанчжан хааны цэргийг ерөнхийлөн захирч, Монгол гүрний төрийг түлхэн унаган Бээжинг эзэлсэн цэргийн жанжин. «Мин ши» (Мин улсын түүх)-ийн 125-р бүлэгт түүний намтарыг ихээхэн магтаж бичсэн байдаг.

Тэрээр Бээжинг эзлэхдээ Монголын хаадын архивыг олзлов гэж бичсэн байдаг.

<sup>5</sup> 1410 онд Юн Лэ хаан биеэр 10 түмэн их цэрэгтэй монголыг довтолсон. Энэ нь түүний монголыг 5 удаа довтолсны анхных нь юм. Тэрээр Онон голын хөвөөнд Бунышир хааны цэрэгтэй байлдах үед нэн их ном судар шатааж түүх дурсгал эвдлэн устгасан гэдэг. Юн Лэ гэдэг нь хааны оны цол бөгөөд жинхэнэ нэр нь Чжу Ди болно. Түүнийг Монгол хатнаас гарсан гэдэг.

<sup>6</sup> Ч, Хишигтогтох, «Монголын нууц товчооны бар хэвлэлийн товч түүх», «Өвөр Монголын багшийн их сургууль», 1980 оны No 4

<sup>7</sup> Сун Лянь Бээжингээс зугатахдаа нууц товчоог авч явсан гэдэг нь үнэмшил багатай байх. Харин хадгалж байгаа орд газрыг нь сайн мэдэж байгад Сюй Да жанжинд хэлж өгсөн байж магад юм. Мин ши-гийн 128-р бүлэгт Сун Ляний шастир бий.

<sup>8</sup> Мин шигийн 28-р бүлэгт «Ван Вэй удирдан говиос хойш газарт 20 гаруй хүн явуулж хэрэглэгдэхүүн цуглуулав» гэж бичжээ. Тэгэхдээ нууц товчоог олохоор явсан гэж бичсэнгүй. Мин Шигийн 289-р бүлэгт Ван Вэй-гийн шастир бий.

<sup>9</sup> «Чжао-дай цун-шу» номд Ван Гуантайгийн ном 9 дугтуй болон оржээ.

<sup>10</sup> Гу Гуанчэ-гийн өргөсөн нэр нь «Сы-шэ Чжу-ши». Бичсэн ном зохиол нь тийм нэрээр хэвлэгдсэн байдаг.

<sup>11</sup> Палладий (Кафаров П.И.) Старинное монгольское сказание о Чингис-хане. «Труды членов Российской духовной миссии в Пекине» т. IV. 1866 г.

<sup>12</sup> Баяр. Монголын нууц товчоо 3 боть, Хөх хот. , 1985 он Нууц товчоог монгол, хятадаар хамгийн сайн орчуулж тайлбар хийсэн эх эрдэмтэн бол Баяр юм.

<sup>13</sup> Оюундалай Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны академийн түүх судлах хүрээлэнгийн ажилтан, Монголын нууц товчоог судлах ажлыг хийдэг. Элдэнтэйн хамт «Монголын нууц товчооны харьцуулсан дэвтэр», «Монголын нууц товчооны үгсээс сонгон тайлбарласан нь» гэх мэт зохиол бичсэн.

<sup>14</sup> Цэнд Гүн(1875—1932)-гийн хүү Элдэнтэй (1908—1981). Элдэнтэйн хүү Ардаажав болно. Ардаажав одоо Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны түүх судлах хүрээлэнд нууц товчоо судалж байна. Гурван үеэрээ нууц товчоог судалсан.

<sup>15</sup> Дугаржав Монголын нууц товчоог орчин цагийн монгол хэлээр орчуулж хэвлэжээ.

<sup>16</sup> Мансаг, Монголын нууц товчичян. Хөх хот., 1985

<sup>17</sup> Төмөрбагана. Арван тавтын «Монголын нууц товчичян» ба түүнийг судалсан Чин улсын монгол эрдэмтэн Бүймэн, 1987, Хөх хот, Өвөр Монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1987, №2